



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Олс таталтын сургагч багш бэлтгэх сургалт семинар зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Олс таталтын сургагч багш бэлтгэх сургалт семинарыг 2018 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулсугай.

2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах 290.000 /хоёр зуун ерэн мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалт семинарыг урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг мэргэжилтэн /Б.Түвшинбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны...11... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Олс таталтын сургагч багш бэлтгэх
сургалт семинарыг зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын зардал: 1 хоног х 4 цаг 30.000 төг = 120.000 төг	120.000
2.	Заал талбайн зардал	100.000
3.	Сертификат хэвлүүлэх	70.000
Нийт дүн		290.000

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны...*11 дугаар*... сарын *19*...-ны өдрийн
А/60 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Олс таталтын сургагч багш бэлтгэх
сургалт семинарт хичээл заах багш
нарын бүрэлдэхүүн

- | | |
|-------------------------|--------------|
| 1. MOTX-ны сургагч багш | А.Адъяахүү |
| 2. MOTX-ны сургагч багш | С.Баяржаргал |
| 3. MOTX-ны сургагч багш | Ч.Болдсайхан |